



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ӨМНӨДЭЛГЭР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 10 сарын 31 өдөр

Дугаар А/306

Өмнөдэлгэр сум

Б.Сайнтерд дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журмын 2.1.4, 2.1.5 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Франц улсын Парис хотноо зохион байгуулагдах 2025 оны жудо бөхийн дэлхийн аварга шалгаруулах “Гранд мастерс” тэмцээнд эх орноо төлөөлөн оролцох тус сумын 2-р багийн иргэн Бат-Эрдэний Сайнтерийн хүсэлтийг үндэслэн дэмжлэг үзүүлсүгэй.

2.Дэмжлэг үзүүлэхэд шаардагдах 1.000.000 (нэг сая) төгрөгийг Засаг даргын нөөц сангаас зарцуулахыг нягтлан бодогч (Б.Гантулга)-д зөвшөөрсүгэй.



Р.ЭНХТӨР

2325310504

D:\disk\bichig hereg/zahiramj



**ХЭНТИЙ АЙМАГ
ӨМНӨДЭЛГЭР СУМ
ХЭЙЛТИ АНИМАЛ СТРОНГ ХХК**

23149 Айрагийн энгэр, Өмнөдэлгэр сум

Утас: 976+98841441

И-Мэйл: ahuuna2021@gmail.com

№ 2025.10.24

танай _____-ны № 03 _____-т

**ХЭНТИЙ АЙМГИЙН ӨМНӨДЭЛГЭР СУМЫН ЗАСАГ
ДАРГА Р.ЭНХТӨР ТАНАА**


Хүсэлт гаргах нь:

Хэнтий аймгийн Өмнөдэлгэр сумын иргэн Б.Сайнтер /CP95112019/ миний бие Франц улсын Парис хотноо зохион байгуулагдах 2025 оны жүдо бөхийн дэлхийн аварга шалгаруулах "Гранд мастерс" тэмцээний М1 ангилалын 60кг жинд Монгол улсаа төлөөлөн оролцох эрхээ авч 2025 оны 10-р сарын 31-ээс 2025 оны 11 сарын 07-ны хооронд явахаар бэлтгэлээ хангаад байна.

Тэмцээний зардалыг 100% хувиасаа хариуцах бөгөөд нийт 3000-4000 орчим еврогийн зардал гарах тооцооллыг Жүдо бөхийн холбооноос танилцуулсан.

Иймд тус тэмцээнд эх орноо төлөөлөн аймаг, сум орон нутгийнхаа нэрийг гарган оролцоход санхүүгийн дэмжлэг үзүүлж хамтран ажиллахыг хичээнгүйлэн хүсье.

ХҮСЭЛТ ГАРГАСАН:



Б.САЙНТӨР



ХЭНТИЙ АЙМГИЙН
ӨМНӨДЭЛГЭР СУМЫН ЗДТГ-Т

МОНГОЛЫН ЖУДО БӨХИЙН ХОЛБОО MONGOLIAN JUDO ASSOCIATION

Монгол Улс, Улаанбаатар хот, Бага тойруу-55

Спортын төв ордон №105,

Утас/Факс: 976-9623-6666

Э-шуудан: judodata01@gmail.com

2025.10.27 № 378

Танай _____ -ны _____ -Т

Зардал хүсэх тухай

Таны энэ өдрийн амар амгаланг өрье. Монголын жүдо бөхийн холбоо, Гранд Мастерсын шигшээ багийн дасгалжуулагч, тамирчид 2025 оны 11 дүгээр сарын 3 – 7 – ны өдрүүдэд Франц улсын Париж хотноо зохион байгуулагдах Гранд Мастерсын дэлхийн аварга шалгаруулах тэмцээн зохион байгуулагдах гэж байна.

Иймд Хэнтий аймаг Өмнөдэлгэр сумын уугуул М1 ангилалын – 60 кг жинд оролцох Бат-Эрдэнэ овогтой Сайнтерд холбогдох зардлыг гарган өгч тусалма уу.

Үүнд:

1. Нислэгийн тийз: 3.600.000 ₮
2. Албан ёсны зочид буудал: 2 хоног X 95 евро = 190 евро X 4.197 ₮ = 797.430 ₮
3. Албан бус зочид буудал: 5 хоног 80 евро = 400 евро X 4.197 ₮ = 1.678.800 ₮
4. Мандатны төлбөр: 160 евро X 4.197 ₮ = 671.520 ₮
5. Тээвэр: 2 талдаа 100 евро X 4.197 ₮ = 419.700 ₮
6. Нийт дүн: 7.167.450 ₮


Дашрамд дурдахад Монгол улсад жүдо бөхийг хөгжүүлэх үйлсэд бидэнтэй байнга хамтран ажиллаж байгаа танд болон танай хамт олонд гүн талархал илэрхийлье.

Хүндэтгэсэн,

ЕРӨНХИЙ НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА



Б. БАТГЭРЭЛ



Овог, нэр: Бат-Эрдэнэ овогтой Сайдтөр

Регистр: CP95112019

Дансны дугаар: Хаан банк: 700005005951256818